# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 22 өдөр Дугаар 48 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчигээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XVII.1.2.7 Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний хүрээнд Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 451 дүгээр тушаалаар батлагдсан Эрүүл мэнд, спортын яам, Гэнэтийн хүчин зүйлийн дагуу хийгдэх засвар /Улаанбаатар, Сүхбаатар/ ажлын төсвөөс "Монгол Солонгосын Дорнын Анагаах Ухааны төв"-ийн эмчлүүлэгчидийн өрөөнүүдийн засвар шинэчлэлийн ажилд 15,037,036 /Арван таван сая гучин долоон мянга гучин зургаан/ төгрөгийн төсвийн зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төв /Л.Жамбалжав/-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төв /Л.Жамбалжав/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОЮУНБААТАР

080171